



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЪЯА БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАР

Нийцлийн аудитын тайлан

Монгол Улсын Засгийн газрын тусгай сангийн үйл ажиллагааны
үр дүн



**ЗАСГИЙН ГАЗРЫН ТУСГАЙ САНГИЙН ХӨРӨНГИЙГ
ХУУЛЬ ТОГТООМЖТОЙ УЯЛДУУЛАН БҮРДҮҮЛЖ,
ЗОРИУЛАЛТЫН ДАГУУ ЗАРЦУУЛЖЭЭ**

2016 он

АГУУЛГА

Тайланг бэлтгэсэн:

Үндэсний Аудитын газрын
харъяа Баян-Өлгий аймгийн
аудитын газар

Аймгийн аудитын газрын
дарга, тэргүүлэх аудиторын
албан үүргийг түр орон
гүйцэтгэгч
Х.Бекен

Аудитын менежер:
Х.Женисбек

Ахлах шинжээч
С.Салтанат

Шинжээч
Х.Еркебулан

2016 оны 10 дугаар сар

Аудитын тайлан, дүгнэлттэй
холбоотой асуудлаар нэмж
тодруулах, асууж лавлах зүйл
байвал 70423073 дугаарын
утас, 70422954 дугаарын
факсаар харилцана уу.

ХАЯГ:
Аймгийн ЗДТГазрын байр, 1
дүгээр давхар 102, 104 тоот
өрөө

Товчилсон үгийн тайлбар3

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй.....4

**Бүлэг 1. Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангаас
2015 онд 163.8 сая төгрөгийн, 2016 оны эхний хагас жилд
117.3 сая төгрөгийн тэтгэлэгийн санхүүжилтийг дутуу
олгожээ.**

- Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн үйл
ажиллагааг зохицуулах эрх зүйн орчин бүрэн бүрдэж,
түүнийг мөрдөж ажилласан байна.....7
- 2015 он, 2016 оны эхний хагас жилийн сангийн хөрөнгийг
зохих журмаар төлөвлөсөн
байна.....8
- Сангийн хөрөнгийг холбогдох хууль, тогтоомж, журмын
дагуу зарцуулж, зохих үр дүнд хүрсэн байна.....11
- Сангийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналтын
тогтолцоог бүрдүүлж, хэрэгжүүлж ирсэн
байна.....15
- Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажилласан
байна.....16

**Бүлэг 2. Байгаль орчныг хамгаалах санд орон нутгийн
төсвөөс 2015-2016 онд 120.3 сая төгрөгийн хөрөнгийг
хуваарилж, зарцуулжээ.**

- Байгаль хамгаалах сангийн тухай хууль, эрх зүйн
актуудыг мөрдөж ажилласан байна.....20
- Байгаль хамгаалах санд орон нутгаас 2015 онд 61.1 сая
төгрөгийн, 2016 оны 9 сарын байдлаар 50.0 сая
төгрөгийн хөрөнгийг тус тус төвлөрүүлсэн байна....21
- Байгаль орчныг хамгаалах сангийн хөрөнгийг
зориулалтын дагуу үр дүнтэй зарцуулж, худалдан авах
ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулжээ....22
- Байгаль орчныг хамгаалах сангийн үйл ажиллагаанд
тавих дотоодын хяналтыг зохих түвшинд зохион
байгуулсан байна.....26
- Шилэн дансны тухай хуулийн зарим заалтуудыг
хангалтгүй хэрэгжүүлсэн байна.....27

Дүгнэлт.....17, 28

Зөвлөмж:18, 29

Холбогдох байгууллагын санал:
.....19, 30

Саналд өгсөн тайлбар
.....

Товчилсон үгийн тайлбар

УИХ	Улсын Их Хурал
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
МСҮТ	Мэргэжлийн Сургалт Үйлдвэрлэлийн төв
БОГ	Байгаль Орчны газар
БОНХАЖЯ	Байгаль Орчин Ногоон хөгжил аялал жуулчлалын яам
ХЯ	Хөдөлмөрийн яам
БСШУЯ	Боловсрол соёл Шинжлэх ухааны яам

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

Аудитын зорилт

УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2016 оны “Аудитын сэдэв батлах тухай” 01 дүгээр тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторт ЯАГ-аас 2016 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөө, Монгол Улсын Ерөнхий аудиторос баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу Засгийн газрын тусгай сангийн хөрөнгийн төлөвлөлт, зарцуулалт, хэрэгжилт, түүнд тавих хяналтыг хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулсан эсэхэд нийцлийн аудит хийж, гарсан зөрчил, дутагдлуудыг арилгах, цаашид засаж сайжруулах санал, зөвлөмж боловсруулан дүнг ЯАГ, холбогдох байгууллага, албан тушаалтнуудад танилцуулахад аудитын зорилт чиглэгдлээ.

Дээрх зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг хийж гүйцэтгэсэн болно. Үүнд:

- Хууль эрх зүйн зохицуулалт оновчтой эсэх
- Сангийн хөрөнгийг хуульд заасны дагуу төлөвлөж, бүрэн бүрдүүлсэн эсэх
- Сангийн хөрөнгийг хууль, тогтоомжид заасны дагуу зарцуулж, үр дүн гарсан эсэх
- Дотоод хяналт үр нөлөөтэй хэрэгжиж байгаа эсэх

Хамарсан хүрээ

Энэхүү аудитад Мэргэжлийн боловсролыг дэмжих сан, Байгаль орчныг хамгаалах сангийн 2015 он, 2016 оны эхний 9 сарын үйл ажиллагааг хамруулж БОНХАЖЯ, ХЯ, БСШУЯ, аймгийн ИТХурлаас гаргасан холбогдох шийдвэрүүд, аймгийн Санхүү, Төрийн сангийн хэлтэс, МСҮТөв болон БОГазрын холбогдох санхүүгийн болон ажлын тайлан, бусад холбогдох тооцоо судалгаанд үндэслэн аудитыг хэрэгжүүлэв.

Эрсдлийн үнэлгээ

Аудитын төлөвлөлтийн үе шатны ажлын явцад цуглуулж судалсан баримт, материал, хамрах хүрээ, нөхцөл байдалд хийсэн урьдчилсан дүн шинжилгээнд үндэслэн хийх аудитын эрсдэлийн ерөнхий үнэлгээг “Дунд” гэж үзлээ.

Аудитын арга зүй

Аудитыг АДБОУС 100-400, 3000, 3100, 4000, 4200, Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн болон нийцлийн аудитын арга зүйг ашиглан, холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, судалгаа авах, харьцуулах, нэгтгэх, фото зургаар баримтжуулах, дүн шинжилгээ хийх зэрэг арга

зүйг ашиглан, аудитын горимын дагуу нотлох баримтуудыг цуглуулж, дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

Аудитад ашиглах шалгуур үзүүлэлтүүд

Аудитын зорилттой холбоотой дараахь хууль тогтоомж, дүрэм, журам, заавар, эрх зүйн актуудыг шалгуур үзүүлэлт болгон ашиглав. Үүнд:

- Монгол Улсын Үндсэн хууль
- Төрийн аудитын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Засгийн газрын тусгай сангийн тухай хууль
- Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль
- Байгаль орчныг хамгаалах тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, түүнд хяналт тавих журам
- Холбогдох бусад хууль тогтоомж, эрхийн акт, стандарт.

Үндсэн мэдээлэл

“Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сан”

“Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай” хуулийн 21-26 дугаар зүйлийг үндэслэн 2010 онд Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сан байгуулагдаж Засгийн газрын тогтоолоор “Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, түүнд хяналт тавих журам”-ыг баталсан байна.

“Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай” хуульд заасны дагуу уг сангийн санхүүгийн удирдлагын үүргийг Хөдөлмөрийн сайд эрхлэх бөгөөд сангийн хөрөнгийн зарцуулалтад боловсрол, санхүү, хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, мэргэжлийн боловсрол, сургалтын Үндэсний зөвлөл хяналт тавьж ажилладаг байна.

2016 оны эхний хагас жилийн гүйцэтгэлээр аймаг, нийслэлд байрлах 28 хувийн болон төрийн өмчит мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвүүдийн хувьсах зардлын санхүүжилтэд 3.2 тэрбум төгрөг, 71 мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвүүдийн 37529 суралцагчдын тэтгэлгийн санхүүжилтэд 7.9 тэрбум төгрөгийн санхүүжилтүүдийг тус тус олгосон байна.

Аймгийн МСҮТөв нь 2015 оны сургалтанд 754 сурагч хамруулж нийтдээ 527.8 сая төгрөгийн тэтгэлэг олгохоор төлөвлөсөн боловч гүйцэтгэлээр 735 сурагч хамруулж, 480.7 сая төгрөгийн тэтгэлэг олгох, 2016 оны сургалтанд 642 сурагч хамруулж нийтдээ 449.4 сая төгрөгийн тэтгэлэг олгохоор төлөвлөсөн ба эхний хагас жилийн гүйцэтгэлээр 609 сурагч хамруулж, 210.5 сая төгрөгийн тэтгэлэг олгохоор тооцоо гарчээ.

“Байгаль хамгаалах сан”

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 34 дүгээр зүйлд заасныг үндэслэн Засгийн газрын 1998 оны 188 дугаар тогтоолоор “Байгаль хамгаалах сан”-г анх байгуулж, 2012 оны 189 дүгээр тогтоолоор “Байгаль хамгаалах сан”-гийн журам болон зохион байгуулалт, орон тооны хязгаарыг, Байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний тушаалаар “Удирдах зөвлөл”-ийн бүрэлдэхүүнийг тус тус баталсан байна.

Байгаль орчны төлөв байдлын өөрчлөлтийг судлан тогтоох, байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, байгаль орчинд үзүүлэх хорт нөлөөллийг багасгах дэвшилтэт технологи нэвтрүүлэх, байгаль орчныг хамгаалахтай холбогдсон хууль тогтоомжийг сурталчлах, хэрэгжилтэд нь хяналт тавих үйл ажиллагаанд иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудын оролцоог нэмэгдүүлэн иргэдэд экологийн боловсрол олгох чиглэлээр сангийн хөрөнгийг оновчтой үр ашигтай зарцуулахад тус сангийн зорилго оршиж байна.

Тус аймгийн Байгаль хамгаалах санд аймгийн ИТХурлын 2015 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн хуралдаанаар 2015 онд 61.0 сая төгрөгийн, 2015 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн хуралдааны 63 тоот тогтоолоор 2016 онд 59.2 сая төгрөгийн хөрөнгийг тус тус төлөвлөж, баталсан байна. Улсын төсвөөс 2015, 2016 онд хөрөнгө хуваарилаагүй байна.

Бүлэг 1

Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангаас 2015 онд 163.8 сая төгрөгийн, 2016 оны эхний хагас жилд 117.3 сая төгрөгийн тэтгэлэгийн санхүүжилтийг дутуу олгосон байна.

Оршил

Монгол Улсын Ерөнхий аудиторос баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу Засгийн газрын тусгай сангийн хөрөнгийн 2015 он, 2016 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаарх үйл ажиллагаанд хийх нийцлийн аудитад Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сан, Байгаль орчныг хамгаалах сангийн үйл ажиллагааг хамруулж 2016 оны 08 дугаар сарын 26-ны өдрөөс 10 дугаар сарын 07-ныг хүртэл хугацаанд нийцлийн аудит хийлээ.

Энэхүү сангуудын үйл ажиллагаанд хийх аудитыг ахлах шинжээч С.Салтанат, шинжээч Х.Еркебулан нарын бүрэлдэхүүнтэй аудитын баг хэрэгжүүлж, аудитын тайланг бэлтгэв.

А. Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн үйл ажиллагааны талаар.

1. Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн хууль эрх зүйн зохицуулалтын талаар.

Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн үйл ажиллагааг зохицуулах эрх зүйн орчин бүрэн бүрдсэн байна.

1.1. Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн сангийн үйл ажиллагааг зохицуулах эрх зүйн орчны талаар.

Мэргэжлийн боловсрол, сургалтын агуулга, зорилго, бүтэц, түүний удирдлага, зохион байгуулалтыг тодорхойлж, иргэнд мэргэжлийн боловсрол эзэмшүүлэх, мэргэжлийн ур чадвар олгох, дээшлүүлэх сургалтыг хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээ, ажил олгогчийн захиалгад нийцүүлэн зохион байгуулах, энэ үйл ажиллагаанд оролцогчийн эрх, үүрэгтэй холбогдсон харилцааг зохицуулах зорилгоор Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийг Монгол Улсын Их Хурлаас 2009 оны 02 дугаар сарын 13-ны өдөр баталсан байна.

Мэргэжлийн боловсрол, сургалтын зорилго нь иргэний авьяас, сонирхол, хөдөлмөр эрхлэх хэрэгцээнд тулгуурлан боловсролын үндсэн зарчим, олон улсын нийтлэг жишиг, хандлагад нийцүүлэн мэргэжлийн ур чадвар, боловсрол эзэмшүүлэх, мэргэшлийг дээшлүүлэх, хөдөлмөрийн болон харилцааны соёл төлөвшүүлэхэд оршино. Дээрхи хууль, бусад журмуудыг баталж мөрдөж ажилласнаар тус сангийн үйл ажиллагааг зохицуулах хууль, эрх зүйн орчин бүрдсэн байна.

1.2. Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн үйл ажиллагааг зохицуулж байгаа хууль, дүрэм, журмуудын талаар.

Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийг баталснаар мэргэжлийн боловсрол, сургалтын талаархи төрийн бодлого, мэргэжлийн боловсрол, сургалтын талаархи иргэний эдлэх эрх, хүлээх үүрэг, үйл ажиллагааны зохион байгуулалтын үндэс, мэргэжлийн боловсрол, сургалтын үйл ажиллагааны санхүүжилт зэрэг бусад үйл ажиллагааг Үндсэн хууль, Боловсролын тухай хууль, Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн заалтуудад уялдуулан зохицуулсан байна.

Хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.3, 8.4-т заасны дагуу мэргэжлийн боловсрол, сургалтын талаархи төрийн бодлого, Засгийн газрын болон энэ хуулийн 6.1-д заасан Зөвлөлийн шийдвэрийг мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хэрэгжүүлэх ёстой.

Энэхүү хуулийг хэрэгжүүлэх үүднээс Засгийн газрын 2011 оны 117 тоот тогтоолоор “Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, түүнд хяналт тавих тухай журам”, Засгийн газрын 2007 оны 294 дүгээр тогтоол, 2015 оны 477 тогтоолоор “Тэтгэлэг олгох тухай журам” тус тус батлагдсан байна.

Дээрхи хууль, журмууд нь сангийн үйл ажиллагааг бүрэн зохицуулж ирсэн байна.

1.3. Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн үйл ажиллагааг зохицуулж буй хууль, дүрэм, журмууд нь бусад хууль, тогтоомжтой нийцэж байгаа талаар.

Сангийн үйл ажиллагааг зохицуулж буй хууль, дүрэм, журмууд нь Үндсэн хууль, Боловсролын тухай хууль, Бага, дунд боловсролын тухай хууль, Дээд боловсролын тухай хууль, Төсвийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай болон бусад хууль, тогтоомжтой нийцсэн байна.

2. Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн хөрөнгийн төлөвлөлт, бүрдүүлэлтийн талаар.

Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн хөрөнгийг үндэслэлтэй төлөвлөж, бүрдүүлсэн байна.

2.1. Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн хөрөнгийн төлөвлөлтийн талаар.

2.1.1 Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.3, 8.4-т заасны дагуу мэргэжлийн боловсрол, сургалтын талаархи төрийн бодлого, Засгийн газрын болон энэ хуулийн 6.1-д заасан Зөвлөлийн шийдвэрийг мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хэрэгжүүлэх ёстой байна.

Энэхүү хуулийн заалтуудыг хэрэгжүүлэх үүднээс МСҮТөв нь Засгийн газрын 2011 оны 117 тоот тогтоолоор батлагдсан “Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, түүнд хяналт тавих тухай журам”, Засгийн газрын 2007 оны 294 дүгээр тогтоол, 2015 оны 477 тогтоолоор батлагдсан

“Тэтгэлэг олгох тухай журам”-уудыг мөрдлөг болгож 2015, 2016 онд тодорхой ажлуудыг зохион байгуулж ажилласан байна.

2.2.2. Хуулинд зааснаар иргэнд мэргэжлийн боловсрол эзэмшүүлэх, мэргэжлийн ур чадвар олгох, дээшлүүлэх сургалтыг хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээ, ажил олгогчийн захиалгад нийцүүлэн зохион байгуулах, үйл ажиллагааг хэрэгжүүлж ирсэн байна.

Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн хөрөнгөнөөс олгосон буюу санхүүжүүлсэн хөрөнгийг төрийн өмчийн мэргэжлийн сургалтын байгууллагын тогтмол зардал, түүнчлэн сурагчийн дотуур байрны нийт зардал, мэргэжлийн өөрийн өртгийг үндэслэн тогтоосон нэг сурагчид ногдох хувьсах зардлаар олгосон санхүүжилт, тэтгэлэг, мэргэжил олгох, давтан сургалт зохион байгуулах зардал, хувиараа аж ахуй эрхлэгч иргэнийг аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх арга барил, ур чадвар эзэмшүүлэхэд сургалтад хамруулах зардал, үйлдвэрлэл дээр мэргэжлийн сургалт зохион байгуулах зэрэг зардалд тус тус хуваарилан зарцуулахаар хуулийн 23 дугаар зүйлийн 23.1-т тодорхой тусгасан байна.

Тус МСҮТөв нь 100 хувь төрийн өмчийн байгууллага тул Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн хөрөнгөөс 2015, 2016 онд зөвхөн тус сургуульд мэргэжил эзэмшиж байгаа сурагчдад тэтгэлэг олгосон ба бусад үйл ажиллагааны зардлуудыг Улсын төсвийн хөрөнгөөс хуваарилж олгосон тул тэтгэлэгийг сонгож нийцлийн аудит хийсэн болно.

2.2.3. Сургалтын байгууллага нь үйл ажиллагаа явуулахын тулд дараах шаардлагыг хангасан байх ёстой байна. Үүнд:

- “Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын суралцагчид тэтгэлэг олгох журам”-ын 2.1.1-д заасны дагуу мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас сургалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан байх ба тус сургууль нь энэхүү тусгай зөвшөөрлийг төв байгууллагаас 2002, 2005, 2013 онд тус тус авчээ. 2002/20 дугаартай тусгай зөвшөөрлийн хавсралтад мэргэжлийн сургалтын 1 жилийн 15 төрлийн мэргэжлийн, 2.5 жилийн 15 төрлийн мэргэжлийн боловсролыг тус тус олгох зөвшөөрлийг авч батлуулсан байна.
- Дээрхи журмын 2.1.2-т заасны дагуу хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, орон нутгийн захиалгад үндэслэн жил бүр элсэлтийн хяналтын тоог төв байгууллагаар батлуулсан байх ба 2014-2015 оны хичээлийн жилд шинээр элсэгчдийн тоог тогтоохдоо 1 жилийн мэргэжлийн сургалтын хувьд 11 мэргэжлээр 250 хүүхдээр, 2.5 жилийн мэргэжлийн боловсролын сургалтын хувьд 11 мэргэжлээр мөн 250 хүүхдээр буюу нийтдээ 500 хүүхдээр төлөвлөж батлуулсан байна.

2015-2016 оны хичээлийн жилд шинээр элсэгчдийн тоог тогтоохдоо 1 жилийн мэргэжлийн сургалтад 8 мэргэжлээр 127 хүүхэд, 2.5 жилийн мэргэжлийн боловсролын сургалтад 12 мэргэжлээр 175 хүүхэд буюу бүгд 302 хүүхдээр төлөвлөж батлуулсан байна.

Шинэ хичээлийн жилийн эхэнд элсэгчдийн тоо их байсан тул Хөдөлмөрийн яаманд асуудал тавьж 2.5 жилийн тогоочийн ангид 15, оёдолын ангид 15, бүгд 30

суралцагчийг элсэлт дүүрээгүй бусад аймгуудын хяналтын тооноос эрх шилжүүлж авснаар нийтдээ 332 хүүхдийг шинээр элсүүлэхээр батлуулжээ.

- Мөн журмын 2.1.3-т зааснаар тухайн жилийн сургалтын агуулга, хөтөлбөр, төлөвлөгөөг төрийн захиргааны төв байгууллагаар батлуулсан байх ёстой ба 2.5 жилийн 12 мэргэжлийн сургалтын төлөвлөгөөг 2013 оны 09 дүгээр сарын 03-ны өдөр Хөдөлмөрийн яамны Мэргэжлийн боловсрол, сургалтын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргаар батлуулжээ.
- 1 жилийн 13 мэргэжлийн сургалтын төлөвлөгөөг 2014 оны 09 дүгээр сарын 01-ний өдөр Хөдөлмөрийн яамны Мэргэжлийн боловсрол, сургалтын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргаар батлуулсан байна.
- Сургалтын агуулга, хөтөлбөрийн хувьд Үндэсний хэмжээнд мөрдөгдөж буй 35 загвар чадамжинд суурилсан сургалтын хөтөлбөрөөс авч сургалтын төлөвлөгөөтэй уялдуулан сургуулийн мэргэжлийн багш нарын баг боловсруулалт хийж, сургалтын албаар батлуулан мөрдөж ажиллажээ.

2.3.4. Тус МСҮТөвийн 2015, 2016 онд Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангаас олгох тэтгэлэгийг төлөвлөсөн байдлыг судлаж үзэхэд 2014 оны 9-р сард 980 суралцагч суралцахаар байсан бол 2015 оны 1-р сард 226 суралцагч төгсгөж, 2015 оны төсвийн төлөвлөгөөнд 754 суралцагчид нийтдээ 527.8 сая төгрөгийн тэтгэлэг олгохоор тооцож төлөвлөсөн байна. Хүснэгт №01

2015 онд төлөвлөгдсөн тэтгэлэг						2016 онд төлөвлөгдсөн тэтгэлэг					
2014 оны 9-р сард	2015 оны 1-р сард төгсөх	2015 оны төсөвт оруулах суралцагчдын тоо	Нэг сард олгох тэтгэлэг /МУЗГ-ын 329-р тогтоол /мян.төг/	Хичээлийн жилд олгох хугацаа сараар /МУЗГ-ын 2015 оны 477-р тогтоол/	2015 онд сангаас олгох нийт тэтгэлэг /сая.төг/	2016 оны төсөвт оруулах суралцагчдын тоо /2015-1-1-нээс 2015-7-1-ний хооронд тоо	2016 оны 9-р сараас 12-р сарын 31-ний хооронд суралцах хүүхдийн тоо	2016 оны төсөвт оруулах суралцагчдын нийт дундаж тоо	Нэг сард олгох тэтгэлэг /МУЗГ-ын 329-р тогтоол/ мян.төг/	Хичээлийн жилд олгох хугацаа сараар /МУЗГ-ын 2015 оны 477-р тогтоол/	2016 онд сангаас олгох нийт тэтгэлэг /сая.төг/
980	226	754	70.0	10	527.8	572	747	642	70.0	10	449.4

2016 онд сангаас авах суралцагчдын тоо, авах тэтгэлэгийн хэмжээг тооцсон байдлыг судалж үзэхэд 2016 оны 9-р сараас 12-р сарын 31-ний хооронд 747 суралцагч байхаар, 2016 оны 9-р сард шинээр элсэх, 2016 оны 1-р сард төгсөх суралцагчдын тоог харгалзан дундажаар 642 суралцагчид нийтдээ 449.4 сая төгрөгийн тэтгэлэг олгохоор тооцож, төлөвлөсөн байна.

Үүнээс үзэхэд 2015, 2016 онд олгох тэтгэлэгийг холбогдох журмын дагуу үндэслэлтэй төлөвлөсөн байна.

2.2. Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн хөрөнгийн бүрдүүлэлтийн талаар.

2.2.1. Тус сургууль нь 2015 оны сургалтанд 754 сурагч хамруулж нийтдээ 527.8 сая төгрөгийн тэтгэлэг олгохоор төлөвлөсөн боловч гүйцэтгэлээр 735 сурагч хамруулж 480.7 сая төгрөгийн тэтгэлэг олгох тооцоо гарсан байна. Тухайн онд МБДСангаас авах ёстой санхүүжилтийн 65,9 хувийг буюу 316.9 сая төгрөгийн санхүүжилт авч, оны эцэст 163.8 сая төгрөгийн тэтгэлэгийн авлагатай гарсан байна. Хүснэгт №02

2015 он								2016 он							
Төлөвлөгөө		Гүйцэтгэл		Олгосон нь		Зөрүү		Төлөвлөгөө		Гүйцэтгэл		Олгосон нь		Зөрүү	
Хүүхдийн тоо	Тэтгэлэг сая.төг	Хүүхдийн тоо	Тэтгэлэг сая.төг	Хүүхдийн тоо	Тэтгэлэг сая.төг	Хүүхдийн тоо	Тэтгэлэг сая.төг	Хүүхдийн тоо	Тэтгэлэг сая.төг	Хүүхдийн тоо	Тэтгэлэг сая.төг	Хүүхдийн тоо	Тэтгэлэг сая.төг	Хүүхдийн тоо	Тэтгэлэг сая.төг
754	527.8	735	480.8	735	316.9	0	163.8	642	449.4	609	210.5	609	93.2	0	117.3

2016 оны сургалтанд 642 сурагч хамруулж нийтдээ 449.4 сая төгрөгийн тэтгэлэг олгохоор төлөвлөсөн ба эхний хагас жилийн гүйцэтгэлээр 609 сурагч хамруулж 210.5 сая төгрөгийн тэтгэлэг олгох тооцоо гарчээ.

Өнгөрсөн оны 163.8 сая төгрөгийн тэтгэлэгийн авлагыг оруулан тооцоход эхний 5 сард 257.0 сая төгрөгийн санхүүжилт авч, 2016 оны эхний хагас жилийн тооцоогоор 117.3 сая төгрөгийн авлагатай гарсан байна.

3. Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн хөрөнгийн зарцуулалтын талаар.

Сангийн хөрөнгийг холбогдох хууль, тогтоомжийн дагуу зарцуулж, зохих үр дүнд хүрсэн байна.

3.1. Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөр нь хуулиар тодорхойлсон зорилго, зорилттой нийцэж байгаа эсэх талаар.

3.1.1 МСҮТөв нь Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангаас 2015-2016 онд авах тэтгэлэгийг Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 21, 22, 23 дугаар зүйл, Засгийн газрын 2011 оны 117 тоот тогтоолоор батлагдсан “Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, түүнд хяналт тавих тухай журам”, Засгийн газрын 2007 оны 294 дүгээр тогтоол, 2015 оны 477 тогтоолоор батлагдсан “Тэтгэлэг олгох тухай журам”-уудын дагуу тооцож төлөвлөж, 2015 онд 480.7 сая төгрөгийн, 2016 оны эхний хагас жилд 210.5 сая төгрөгийн тэтгэлэгийн санхүүжилтийг авч суралцагчдад олгосон нь хуулиар тодорхойлсон зорилго, зорилттой нийцэж байна.

3.2. Төсөл, хөтөлбөрийг ТБОНӨХБАҮХАТХ-ийн дагуу сонгон шалгаруулсан эсэх талаар.

3.2.1 Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 14.4, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль болон “Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль”-ийн холбогдох заалтууд, Засгийн газрын 2011 оны 117 дугаар тогтоолоор батлагдсан “Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, түүнд хяналт тавих журам”-ын 3.4-т заасны дагуу Хөдөлмөрийн яам, Мэргэжлийн боловсрол, сургалтын Үндэсний зөвлөлөөс бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг түүгээрээ зохион байгуулж, аймгуудыг зохих хэмжээний хөрөнгө оруулалтаар хангасан байна. Тухайлбал:

Дээд байгууллагаас нь 2015 онд 144.8 сая төгрөгийн үндсэн хөрөнгө, 105.1 сая төгрөгийн багаж хэрэгсэл, аж ахуйн материал, 2016 оны эхний хагас жилд 55.3 сая төгрөгийн аж ахуйн материалаар хангасан байна.

3.3. Сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр нь гэрээний шаардлагыг хангасан эсэх талаар.

3.3.1. Холбогдох хууль, журмын дагуу төсөл, хөтөлбөрөөр хэрэгжүүлсэн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг Хөдөлмөрийн яам, Мэргэжлийн боловсрол, сургалтын Үндэсний зөвлөлөөс түүгээрээ зохион байгуулж, аймгуудыг зохих хэмжээний хөрөнгө оруулалтаар хангасан тул гэрээний шаардлагыг хангасан гэж үзэх үндэстэй байна.

3.4. Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөр нь зорилтот үр дүндээ хүрсэн эсэх талаар.

3.4.1. “Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын суралцагчид тэтгэлэг олгох журам”-ын 1.2-т “Сургалтын байгууллагын мэргэжлийн боловсролын 1 болон 2.5 жил, техникийн боловсролын 1.5 болон 3 жилийн сургалтад хамрагдаж байгаа 24 хүртэлх насны суралцагчид тэтгэлэг олгоно” гэж заасны дагуу 2015, 2016 онд сургуульд суралцагчдын тоог жил бүрийн 9-р сард захирлын тушаалаар тогтоож, тухайн онд төгсөгчид, сургуулиас завсардсан, хасагдсан, жилийн чөлөө авсан суралцагчдын талаар мөн захирлын шийдвэрээр чөлөөлж, өмнөх онд чөлөө авч орж ирсэн, анги хооронд шилжсэн суралцагчдын талаар захирлын шийдвэр гарч тухайн сар, онд суралцагчдын тоог тооцдог байна.

2015, 2016 онд суралцагчдын тоог 2015 он болон 2016 оны 6, 9-р сард гарсан захирлын тушаал, шийдвэрийн хавсралтанд заасан анги, мэргэжил, төгсөгч, шинээр элссэн, жилийн чөлөө авсан, чөлөө авч орж ирсэн, сургуулиас хасагдсан суралцагчийн нэрстэй нэг бүрчлэн тулгаж үзэхэд суралцагчдын тооноос илүү, дутуу гарсан ямар нэгэн зөрчил, дутагдал илрээгүй болно.

Тус сургуульд 2014-2015 оны хичээлийн жилд шинээр 464 суралцагч элсэн орж, 1 жилээр 246 суралцагч, 2.5 жилээр 206 суралцагч төгссөн бол, 2015-2016 оны хичээлийн жилд 419 суралцагч шинээр элсэн орж, 1 жилээр 121 суралцагч, 2.5 жилээр 209 суралцагч тус тус төгссөн байна.

3.4.2. Засгийн газрын 2007 оны 294 дүгээр тогтоолоор батлагдсан “Мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвийн суралцагчдад тэтгэлэг олгох журам”-ын 4-т

“Суралцагч хичээлдээ суугаагүй хугацаанд тэтгэлэг олгохгүй” гэж заасан ба энэхүү тогтоолоор батлагдсан журмын заалт нь 2015 оны 12 дугаар сарын 07-ны өдрийг хүртэл хүчинтэй байсан ба Засгийн газрын 2015 оны 477 дугаар тогтоолоор батлагдсан “Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын суралцагчид тэтгэлэг олгох журам” батлагдсанаар 2015 оны 12 дугаар сарын 7-ны өдрөөр хүчингүй болсон байна.

Энэхүү тогтоолоор батлагдсан “Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын суралцагчид тэтгэлэг олгох журам”-ын 2.2.2-т “хүндэтгэн үзэх шалтгаантайгаас /эрүүл мэндийн болон ар гэрийн гачигдал гэх мэт/ бусад тохиолдолд онолын болон дадлагын сургалтад 75 хувиас доошгүй ирцтэй оролцсон байх” гэж заасан байна.Өөрөөр хэлбэл энэхүү шаардлагыг хангасан суралцагчдад тухайн сарын тэтгэлэгийг 100 хувь олгохоор заасан ба суралцагчдын сургалтад оролцох оролцоо нь 75 хувиас доош байвал тухайн сард тэтгэлэг олгох боломжгүй болох юм байна.

Нөгөө талаар дээрхи журмын 3.4-т “Суралцагч сургалтын байгууллагаас албан ёсны чөлөө авсан, сургуулиа орхисон тохиолдолд тэтгэлийг зогсооно. Энэ тохиолдолд сургалтын байгууллагын эрх бүхий албан тушаалтан албан ёсны шийдвэр гаргасан байна” гэж заасны дагуу чөлөө авсан, сургуулиа орхисон суралцагчдад албан ёсны шийдвэр гаргаж, тэтгэлэгийг зогсоосон байна.

Тухайлбал: Тус сургуулийн захирлын шийдвэрээр 2015 онд 6 суралцагч жилийн чөлөө авч, 3 суралцагч жилийн чөлөөнөөс орж ирсэн бол, 2016 оны эхний хагас жилд 13 суралцагч жилийн чөлөө авч, 9 сурагч сургуулиа орхисон 3 суралцагч Казахстан улс болон Дархан хотод шилжсэн байна.

Суралцагчдын онолын болон дадлагын сургалтад оролцох оролцоо, авсан тэтгэлэгийн тооцоо, бүртгэлийг сургуулийн хичээлийн хуваарь, суралцагчдын журналд байгаа суралцагчийн ирцийн бүртгэлийг хичээлийн хуваарь, анги тус бүрийн журналын сургалтын ирц бүртгэлтэй тулгаж үзэхэд нэг өдрөөр хичээл тасалсан, тухайн өдөрт 2-6 цаг хичээл тасалсан тохиолдлууд байсан боловч тухайн сард 8-10 цагаас илүү буюу 75 хувиас доошгүй ирцтэй оролцсон тохиолдол гараагүй байна.

Харин өмнөх 2015 оны хичээлийн жилийн ирцийн байдлыг Засгийн газрын 2007 оны 294 дүгээр тогтоолоор батлагдсан журмын 4 дүгээр заалтыг үндэслэн хичээлийн хуваарь, анги бүрийн журналын сургалтын ирц, бүртгэлтэй тулгаж үзэхэд суралцагчийн хичээл тасалсан хугацааг нэг бүрчлэн тооцож, тухайн сарын тэтгэлэгийг хичээлд суусан хугацаанд нь тооцож олгосон бөгөөд зөрчил дутагдал гараагүй.

3.4.3 2015, 2016 онд суралцагчийн журналд заасан хичээлийн агуулга, суралцагчийн ирцийн бүртгэлийг хагас, дутуу хөтөлсөн зөрчил, дутагдлуудыг цаашид дахин давтан гаргуулахгүй байх, суралцагчийн журналын хөтлөлт, ирцийн бүртгэлд тавих хяналтыг сайжруулах талаар нийгмийн ажилтан, хяналт шинжилгээ, мониторинг хариуцсан ажилтан, тооцооны нягтлан бодогч, сургалтын албаны ажилтнуудад зөвлөсөн болно.

2015 оны 1-р улиралд МСҮТөв байгуулагдсаны 50 жилийн ойд хандив болгож, тус төвийн захиргааны зөвлөлийн хурлын тэмдэглэл, суралцагчдын зөвшөөрсөн гарын үсгийг үндэслэн суралцагчдын тэтгэлэгээс суралцагч тус бүрээс 5.0 мянган

төгрөгийн нийтдээ 4560.0 мянган төгрөгийг суутгаж, ойн арга хэмжээнд зарцуулсан байна.

Дадлагын хичээлээр суралцагчид 2015 онд нийтдээ 4.9 сая төгрөгийн бүтээгдэхүүн, 2016 оны эхний хагас жилд 4.2 сая төгрөгийн бүтээгдэхүүнийг тус тус дансанд орлого авахуулж, 2015- 2016 онд 1.9 сая төгрөгийн бэлэн мөнгийг дансанд оруулсан байна.



МСҮТөвийн онолын болон дадлагын кабинетүүд

Тус сургууль нь аймгийн Хөдөлмөрийн хэлтэс, ажил олгогч эздийн холбоо, Мэргэжлийн холбоод, аж ахуйн нэгжүүдтэй хамтран ажил, мэргэжлийн эрэлтийн судалгааг гаргаж, тухайн жилийн элсэлтээ тодорхойлдог байна.

Мөн тухайн сургалтын жилд төгсөгчдийн ажил эрхлэлтийн судалгааг нийгмийн түншлэл, ажлын байр хариуцсан мэргэжилтэн аймгийн Хөдөлмөрийн хэлтэстэй

хамтарч 3,6,12 сараар гаргаж, ажилтай орлоготой болгох талаар хамтарч ажилладаг байна.

Тухайбал: 2015-2016 онд нийтдээ 330 суралцагч төгссөнөөс 94 суралцагч буюу 28.5 хувь нь ажилтай, орлоготой болсон нь зохих үр дүнгээ өгсөн байна. Энэхүү ажилтай, орлоготой болсон мэргэжлээс 8.5 хувь нь үсчин, 9.6 хувь нь оёдолчин, 8.5 хувь нь автомашины засварчин, 8.5 хувь нь тогооч, 48.9 хувь нь барилгын чиглэлийн, үлдсэн 16.0 хувь нь бусад мэргэжлийн суралцагч нар байна.

4. Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналтын талаар.

Сангийн хөрөнгийн зарцуулалтанд тавих дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлж, хяналтыг зохих түвшинд хэрэгжүүлсэн байна.

4.1. Дотоод хяналтын үр дүнтэй тогтолцоо бүрдсэн эсэх талаар.

4.1.1. Засгийн газрын 2015 оны 477 дугаар тогтоолоор батлагдсан “Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын суралцагчид тэтгэлэг олгох журам”-ын 3.2-т “Сургалтын байгууллага нь суралцагчийн тухайн сарын ирцийн мэдээллийг энэхүү журмын хавсралтад заасан маягтын дагуу тооцон нэгтгэж, дараа сарын 5-ны өдрийн дотор мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ” тус тус заасан байна.

Энэхүү хууль, журмын дагуу тус МСҮТөв нь суралцагчдад олгох тэтгэлэгийн үйл ажиллагаанд анги удирдсан багш, нийгмийн ажилтан, хяналт, шинжилгээ, мониторинг хариуцсан ажилтан, тооцоо хариуцсан нягтлан бодогч, сургалтын менежер, захирал нар нь тухайн сар бүр хяналт тавьж ирсэн нь сангийн үйл ажиллагаанд тавих дотоодын хяналтыг шат шатандаа бүрдүүлсэн байна.

4.2. Сангийн үйл ажиллагаанд хийгдэж байгаа дотоод хяналт, шалгалтын талаар.

4.2.1. Засгийн газрын 2015 оны 477 дугаар тогтоолоор батлагдсан “Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын суралцагчид тэтгэлэг олгох журам”-ын 3.2-т заасны дагуу тус МСҮТөв нь суралцагчийн тухайн сарын ирцийн мэдээллийг журамд заасан маягтын дагуу тооцон нэгтгэж, дараа сарын 5-ны дотор мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлж ирсэн байна.

Суралцагчдын тухайн сарын ирцийн мэдээллийг ангийн багш болон нийгмийн ажилтан тооцож гаргадаг ба түүнд хяналт шинжилгээ, мониторинг хариуцсан ажилтан хянасны дараа хариуцсан тооцооны нягтлан бодогч тооцооллыг хийж гүйцэтгэснээр сургалтын менежер хянаж, сургуулийн захирал нь танилцаж гарын үсэг зурснаар баталгаажуулан төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлж ирсэн байна.

Төрийн захиргааны төв байгууллага нь энэ журмын 3.2-т заасан мэдээлэл буюу суралцагчийн тухайн сарын ирцийн мэдээллийг хүлээн авч хянаж магадласны үндсэн дээр тэтгэлэгийг суралцагчийн дансанд сар бүр шилжүүлж ирсэн ба зөвхөн 2015 оны 9 дүгээр сард дээд байгууллагаас нь хүүхдийн тоог үнэн зөв гаргахын тулд бэлнээр олгосон байна.

4.2.2. Тус сургуулийн хяналт, шинжилгээ, мониторинг хаиуцсан ажилтан нь сургуулийн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам, төвийн тухайн жилийн үйл ажиллагаанд дотоод хяналт, шалгалт хийх жил, сарын төлөвлөгөөг тус тус боловсруулж, захирлаар батлуулж мөрдөж ажилласан байна.

Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолын дагуу Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд улирал бүр хяналт тавьж суралцагчийн тэтгэлэг олгох үйл ажиллагаанд тавих дотоодын хяналтыг зохих түвшинд зохион байгуулж, хэрэгжүүлсэн байна.

4.3. Шилэн дансны тухай хуульд заасны дагуу мэдээллийг ил тод нээлттэйгээр олон нийтэд мэдээлж байгаа эсэх талаар.

Шилэн дансны тухай хуулийн заалтуудыг бүрэн хэрэгжүүлж ирсэн байна.

3.2.1 Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сан буюу тус байгууллагын Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг аймгийн Аудитын газраас 10, 11 дүгээр сар, 2016 оны 4 дүгээр сард шилэн дансны нэгдсэн мэдээллийн санд байршуулбал зохих мэдээллээ бүрэн байршуулсан эсэхийг шалгахад сангийн талаарх мэдээллүүдээ хугацаанд нь бүрэн байршуулж хуулийн хэрэгжилтийг хангаж ажилласан байна.

Аудит хийх явцад байгууллагад шилэн дансны мэдээллийн самбар байгаа эсэх, мэдээллийг хэрхэн байршуулж байгаа байдлыг газар дээр нь шалгаж үзэхэд мэдээллийн самбарыг заасан стандартаар нь хийж, ил харагдахаар газарт байрлуулж, мэдээллээ хугацаанд нь бүрэн байршуулсан байна.

Нийцлийн аудитын үр дүнгээр ямар нэгэн зөрчил, дутагдал гараагүй ба 1 заалт бүхий зөвлөмжийг холбогдох байгууллага, албан тушаалтнуудад өгсөн болно.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын үр дүнд үндэслэн дараах дүгнэлтүүдийг хийж байна.

1. Мэргэжлийн боловсрол, сургалтын сангийн үйл ажиллагааны талаар.

1. Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн үйл ажиллагааг зохицуулах эрх зүйн орчин бүрэн бүрдсэн байна.
2. 2015 он, 2016 оны эхний хагас жилийн сангийн хөрөнгийг үндэслэлтэй төлөвлөжээ.
3. МБДСангаас 2015 онд 163.7 сая төгрөгийн, 2016 оны эхний хагас жилд 117.4 сая төгрөгийн тэтгэлэгийн санхүүжилтийн авлагатай гарч, тэр хэмжээгээр тэтгэлийн өглөг үүссэн байна.
4. Сангийн хөрөнгийг холбогдох хууль, тогтоомж, журмын дагуу зарцуулж, зохих үр дүнд хүрсэн байна.
5. Сангийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлж, хяналтыг зохих түвшинд зохион байгуулж, хэрэгжүүлсэн байна.
6. Шилэн дансны тухай хуулийн заалтуудыг бүрэн хэрэгжүүлсэн байна.

Зөвлөмж

Аудитын дүнд үндэслэн дор дурьдсан албан тушаалтнуудад дараах зөвлөмжийг өгч байна.

МСҮТөвийн захирал Р.Гүлстан, ахлах нягтлан бодогч Х.Бауыржан нарт.

1. 2015, 2016 онд суралцагчийн журналд заасан хичээлийн агуулга, суралцагчийн ирцийн бүртгэлийг хагас, дутуу хөтөлсөн зөрчил, дутагдлуудыг цаашид дахин давтан гаргуулахгүй байх, засаж залруулах.

Холбогдох байгууллагын санал

(.....Байгууллагын нэрийг оруулах.....) ирүүлсэн санал:

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
МЭРГЭЖЛИЙН СУРГАЛТ
ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТӨВ

63120 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/Факс: (976) 7042-2212, E-mail: maud_bo@yahoo.com

2016.10.04 № 174

Танай _____ -ийн № _____ -т

АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Үндэсний аудитын газраас 2016 онд Монгол Улсын Ерөнхий аудиторт нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу тус аймаг дахь МСҮТөвийн "Мэргэжлийн боловсролыг дэмжих сан"-д хийгдсэн нийцлийн аудит нь холбогдох хууль тогтоомж, аудит хийх эрх бүхий этгээдүүдийн эрх хэмжээний хүрээнд үнэн зөв хийгдсэн болно.

ЗАХИРЛЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Р. ГҮЛСТАН

Р.ГҮЛСТАН

D:\documents\MSUT\Албан тоот\AS.doc

Бүлэг 2

Байгаль орчныг хамгаалах санд орон нутгийн төсвөөс 2015-2016 онд 111.1 сая төгрөгийн хөрөнгийг хуваарилж, зарцуулжээ.

Б. Байгаль орчныг хамгаалах сангийн үйл ажиллагааны талаар:

1. Байгаль орчныг хамгаалах сангийн хууль, эрх зүйн зохицуулалт оновчтой байгаа талаар.

Байгаль хамгаалах сангийн тухай хууль, эрх зүйн актуудыг мөрдөж ажилласан байна.

1.1 Байгаль орчныг хамгаалах сангийн үйл ажиллагааг зохицуулах эрх зүйн орчин бүрдсэн эсэх талаар.

1.1.1 Монгол Улсын Их хурлаас 1995 онд баталсан Байгаль орчныг хамгаалах тухай хуулиар хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах, нийгэм, эдийн засгийн хөгжлийг байгаль орчны тэнцэлтэй уялдуулах, өнөөгийн болон ирээдүйн үеийнхний ашиг сонирхлын үүднээс байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, жам ёсны боломжтойг нь нөхөн сэргээхтэй холбогдсон төр, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хооронд үүсэх харилцааг зохицуулсан байна.

1.1.2 Монгол Улсын Засгийн газрын 1998 оны 188 дугаар тогтоолоор “Байгаль хамгаалах сан байгуулах, зарцуулах журам”-ыг баталж, Байгаль орчныг хамгаалах санг анх байгуулжээ.

Мөн Засгийн газрын 2012 оны 189 дүгээр тогтоолоор “Байгаль хамгаалах сангийн журам”-ыг шинэчилэн баталж, “Байгаль хамгаалах сан”-гийн зохион байгуулалт, орон тооны хязгаарыг, Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын тушаалаар сангийн “Удирдах зөвлөл”-ийн бүрэлдэхүүнийг тус тус баталж, Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Засгийн газрын 2012 оны 189 дүгээр тогтоолоор батлагдсан журмын дагуу үйл ажиллагаа явуулж ирсэн байна.

1.1.3. Байгаль хамгаалах сангийн зорилгыг “Байгаль орчны төлөв байдлын өөрчлөлтийг судлан тогтоох, байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, байгаль орчинд үзүүлэх хорт нөлөөллийг багасгах, дэвшилтэт технологи нэвтрүүлэх, байгаль орчныг хамгаалахтай холбогдсон хууль тогтоомжийг сурталчлах, хэрэгжилтэд нь хяналт тавих үйл ажиллагаанд иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудын оролцоог нэмэгдүүлэн иргэдэд экологийн боловсрол олгох чиглэлээр сангийн хөрөнгийг оновчтой, үр ашигтай зарцуулах” гэж тодорхойлжээ. Дээрхи холбогдох хууль, журмуудыг баталж мөрдөж ажилласнаар тус сангийн үйл ажиллагааг зохицуулах хууль, эрх зүйн орчин бүрдсэн байна.

1.2 Байгаль орчныг хамгаалах сангийн тухай хууль, дүрэм, журмууд нь сангийн үйл ажиллагааг бүрэн зохицуулж чадаж байгаа эсэх талаар.

1.2.1 Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Монгол Улсын засгийн газрын 2012 оны 189 дүгээр тогтоолоор батлагдсан “Байгаль хамгаалах сан байгуулах, зарцуулах журам” нь сангийн үйл ажиллагааг бүрэн зохицуулсан байна.

1.3 Байгаль орчныг хамгаалах сангийн үйл ажиллагааг зохицуулж буй хууль, дүрэм, журмууд нь бусад хууль, тогтоомжтой нийцэж байгаа эсэх талаар.

1.3.1 Байгаль орчныг хамгаалах сангийн үйл ажиллагааг зохицуулж буй Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын “Байгаль хамгаалах сан байгуулах, зарцуулах журам” нь Үндсэн хууль, Төсвийн тухай хууль, Татварын ерөнхий хууль, бусад хууль, тогтоомжтой нийцэж байна.

2. Байгаль орчныг хамгаалах сангийн хөрөнгийг хуульд заасны дагуу төлөвлөж, бүрэн бүрдүүлсэн эсэх талаар.

Байгаль хамгаалах санд орон нутгаас 2015 онд 61.1 сая төгрөгийн, 2016 оны 9 сарын байдлаар 50.0 сая төгрөгийн хөрөнгийг тус тус төвлөрүүлсэн байна.

2.1 Байгаль орчныг хамгаалах сангийн хөрөнгийг хуульд заасны дагуу үндэслэлтэй төлөвлөсөн эсэх талаар.

2.1.1 Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлд аймаг, нийслэлийн ИТХурал, Засаг даргын бүрэн эрхийг тодорхой тусгасан ба Байгаль хамгаалах сангийн хөрөнгийг Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д заасан 6 төрлийн эх үүсвэрээс бүрдүүлэхээр заасан байна.

Аймгийн Байгаль орчныг хамгаалах санд төвлөрүүлэх хөрөнгийг Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 189 дүгээр тогтоолоор батлагдсан “Байгаль орчныг хамгаалах санг бүрдүүлэх, зарцуулах журам”-ын дагуу төлөвлөж ирсэн байна.

Байгаль орчныг хамгаалах сангийн төсвийг орон нутгийн төсвийн бүрэлдэхүүнд оруулан тусдаа баталж, Байгаль орчин аялал жуулчлалын газарт эрх шилжүүлж, тус газрын дансаар дамжуулан захиран зарцуулж ирсэн байна.

2.1.2 Тус аймгийн Байгаль орчныг хамгаалах санд 2015 онд хуваарилах хөрөнгийг аймгийн ИТХурлын 2014 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн хуралдааны 47 дугаар тогтоолоор 80.0 сая төгрөгөөр баталжээ. Мөн аймгийн ИТХурлын 2015 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн хуралдааны 53 тоот тогтоолоор Байгаль орчныг хамгаалах сангийн төсөвт 61.1 сая төгрөгөөр тодотгол хийж, 18.9 сая төгрөгөөр бууруулж баталсан байна.

Байгаль орчныг хамгаалах санд 2016 онд хуваарилах хөрөнгийг аймгийн ИТХурлын 2015 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн хуралдааны 63 тоот тогтоолоор 59.2 сая төгрөгөөр баталжээ.

2.2 Байгаль орчныг хамгаалах сангийн хөрөнгийг хууль, журамд заасны дагуу төрөл тус бүрээр бүрдүүлсэн эсэх талаар.

2.2.1. Байгаль орчныг хамгаалах санг Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 7.1-д заасан Улсын төсвийн хөрөнгө, гадаад, олон улсын байгууллага, дотоодын аж ахуйн нэгж, байгууллага, иргэнээс өгсөн буцалтгүй тусламж, хандив, гадаад улс, олон улсын байгууллагаас засгийн газрын шугамаар олгосон зээлээс гадна энэхүү хуулийн 12 дугаар зүйлд зааснаар тусгай хамгаалалттай газар нутагт байгалийн аялал, жуулчлал эрхлэх эрхийн бичиг олгосны хураамж, байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах хөрөнгийн хувь, хэмжээний тухай хуулийн 4.2 дахь хэсэгт заасан мөнгөн хөрөнгө, ус бохирдуулсны төлбөрийн орлогоос бүрдүүлдэг ёстой байна.

2015, 2016 онд дээрхи орлогын эх үүсвэрээс буюу дээд байгууллагаас нь орон нутгийн Байгаль хамгаалах санд ямар нэгэн хөрөнгө хуваарилаагүй байна.

2.2.2 Тус аймгийн Байгаль орчныг хамгаалах сангийн дансанд орон нутгийн төсвөөс 2015 онд 58.9 сая төгрөгийн, 2016 онд 50.0 сая төгрөгийн хөрөнгийг тус тус төвлөрүүлж зарцуулсан ба 2016 оны 10 дугаар сарын 01-ний байдлаар 13.7 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Байгаль орчныг хамгаалах санд хуваарилсан хөрөнгө, зарцуулалтыг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №01					/сая төгрөг/		
№	Төвлөрүүлсэн хөрөнгө	Оны эхний үлдэгдэл	Анх батлагдсан төсөв	Тодотголоор батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Зөрүү	Оны эцсийн үлдэгдэл
1	2015 онд		80.0	61.1	58.9	-2.2	
2	2016 онд		59.2	59.2	50.0	-9.2	
	Дүн		139,0	120,3	108,9	-11,4	

3. Байгаль орчныг хамгаалах сангийн хөрөнгийг хууль, тогтоомжид заасан зориулалтын дагуу зарцуулж, үр дүн гарсан эсэх талаар.

Байгаль орчныг хамгаалах сангийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулж, худалдан авах ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулжээ.

3.1 Байгаль орчныг хамгаалах сангийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөр нь хуулиар тодорхойлсон зорилго, зорилттой нийцэж байгаа эсэх талаар.

3.1.1. Байгаль орчны санд 2015 онд хуваарилсан 58.9 сая төгрөгийн хөрөнгийн хуваарилалтыг аймгийн Засаг даргаар батлуулж, хуваарийн дагуу зарцуулсан байна.

Тухайлбал: 2.0 сая төгрөгийг ан амьтанд хужир давс тавьж биотехникийн арга хэмжээнд, 0.7 сая төгрөгийг байгалийн ховор ургамал, зэрлэг сармисны нөөцийг тогтоож нөхөн сэргээхэд, 2.3 сая төгрөгийг суулгацаар ойжуулахад, 5.9 сая төгрөгийг байгалийн сэргээн ургалтанд туслахад, 2.8 сая төгрөгийг булаг, шандны эхийг хамгаалах, тохижуулахад, 9.8 сая төгрөгийг аймгийн төвөөс гарах 5 чиглэлийн замын дагуу байгаль хамгаалах сурталчилгааны самбар хийж байрлуулахад, 16.0 сая төгрөгийг Өлгий сумын хүүхэд залуучуудын паркийн гүний 3, Ногоон хашааны бөхөн уул талын 2 гүний өрөмдмөл худгийн зардалд, 3.5 сая төгрөгийг “Ногоон хэрэм” зурвасын дагуу ойн зурвас байгуулахад, 16.8 сая төгрөгийг Толбо сумын чиглэлийн хар замын дагуу ойн зурвасанд усалгаа хийхэд

шаардагдах цахилгааны эх үүсвэрийг шийдэх зэрэг 9 төрлийн төсөл, арга хэмжээнд тус тус зарцуулсан байна.

3.1.2. Байгаль орчны санд 2016 онд төвлөрүүлсэн 50.0 сая төгрөгийн хөрөнгийн хуваарилалтыг мөн аймгийн Засаг даргаар батлуулж, хуваарийн дагуу зарцуулжээ. Үүнд: 5.0 сая төгрөгийг ан амьтанд хужир давс тавьж биотехникийн арга хэмжээ авахад, 3.5 сая төгрөгийг байгаль ургамлын судалгаа хийх, 8.6 сая төгрөгийг өмнөх жилүүдэд хийгдсэн ойжуулалтын ажлын усалгаа, арчилгааны зардалд, 5.0 сая төгрөгийг ойн зувас байгуулахад, 14.2 сая төгрөгийг Толбо сумын чиглэлийн хар замын дагуу ойн зурвасанд усалгааны систем тавих зэрэг төсөл, арга хэмжээнд тус тус зарцуулжээ.

3.1.3 Эдгээр хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнүүдийг баталсаны дараа зураг төсөв, ажлын төсөвт өртгийг хийж, ажлын гүйцэтгэлийг холбогдох нотлох баримтаар баталгаажуулсан байна.

2015, 2016 онд энэхүү сангийн хөрөнгөөр хэрэгжсэн төсөл арга хэмжээнүүд нь байгаль хамгаалах сангийн хуулиар тодорхойлсон зорилго, зорилттой нийцэж байгаа боловч байгалийн эрсдэлтэй унаган төрх байдлыг хамгаалах, бохирдлыг багасгах, эн тэргүүнд шаардлагатай төсөл, арга хэмжээг зөв сонгон авч сангийн хөрөнгийг түүнд чиглүүлэн төлөвлөж, хэрэгжүүлж чадаагүй байна.

Тухайбал: 2015, 2016 онд орон нутгийн төсвөөс төлөвлөсөн сангийн хөрөнгөөс байгаль орчинд үзүүлэх хорт нөлөөллийг багасгах чиглэлийн төсөл, арга хэмжээнд ямар нэгэн хөрөнгө, төсөв хуваарилж, энэ талаар ямар нэгэн төсөл, арга хэмжээ хэрэгжүүлээгүй байна.

3.2 Байгаль орчныг хамгаалах сангийн төсөл, хөтөлбөрийг ТБОНӨХБАҮХАТХ-ийн дагуу сонгон шалгаруулсан эсэх талаар.

3.2.1 Байгаль орчныг хамгаалах сангийн хөрөнгөөр 2015 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 9 төсөл, арга хэмжээний 8-ыг нь Байгаль орчин аялал жуулчлалын газар шууд гэрээ байгуулах замаар хэрэгжүүлсэн байна.

Харин 1 төсөл, арга хэмжээ буюу Толбо сумын чиглэлийн хар замын дагуу ойн зурвасанд усалгаа хийхэд шаардагдах цахилгааны эх үүсвэрийг шийдэх төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг Худалдан авах ажиллагааны алба нээлттэй тендер шалгаруулах замаар худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна.

Худалдан авах ажиллагааны алба нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 33, 34 дүгээр зүйлийг үндэслэн ажлын хэсэг байгуулж, тендер зарлаж, нээлттэй тендер шалгаруулах аргаар шалгаруулж, шалгарсан төсөвт багтаан гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулах саналаа өгч, холбогдох захиалагч байгууллагууд нь гэрээ байгуулж гүйцэтгүүлжээ.

Худалдан авах ажиллагааны албанаас Үнэлгээний хороо байгуулж, тендерийн урилга нийтлэх, гэрээ байгуулах эрх олгох хүртэл хугацаанд энэхүү тендерт ажлын 7 хоног зарцуулжээ.

3.2.2. Байгаль орчныг хамгаалах сангийн хөрөнгө оруулалтаар 2016 онд хэрэгжихээр төлөвлөгдсөн 5 төсөл, арга хэмжээний 4-ийг нь Байгаль орчин аялал жуулчлалын газар шууд гэрээ байгуулах замаар, 1 төсөл, арга хэмжээ буюу Толбо сумын чиглэлийн хар замын дагуу ойн зурвасанд усалгааны систем тавих төсөл,

арга хэмжээг Худалдан авах ажиллагааны алба нээлттэй тендер шалгаруулах замаар худалдан авах ажиллагааг зохион байгуулжээ.

Худалдан авах ажиллагааны алба нь дээрхи 1 төсөл, арга хэмжээг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 33, 34 дүгээр зүйлийг үндэслэн ажлын хэсэг байгуулж, нээлттэй тендер шалгаруулах аргаар шалгаруулж, захиалагч байгууллагууд нь гэрээ байгуулж одоо гүйцэтгэх шатандаа байна.

Худалдан авах ажиллагааны албанаас Үнэлгээний хороо байгуулж, тендерийн урилга нийтлэх, гэрээ байгуулах эрх олгох хүртэл хугацаанд нэг тендерт ажлын 9 хоног зарцуулжээ. Аудитын явцад аймгийн төвд хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээнүүдийг газар дээр нь үзэж танилцав.

3.3 Байгаль орчныг хамгаалах сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр нь гэрээний шаардлагыг хангасан эсэх.

3.3.1 Байгаль хамгаалах сангийн хөрөнгө оруулалтаар 2015 онд хэрэгжүүлсэн 9 төсөл, арга хэмжээ нь гэрээний шаардлагыг бүрэн хангаж, хугацаанд нь ашиглалтанд өгч, гүйцэтгэгч, ашиглагч байгууллагын хооронд ямар нэгэн гомдол, маргаан гараагүй байна.

2016 оны эхний 9 сард хэрэгжүүлсэн 5 төсөл арга хэмжээнээс ан амьтанд хужир давс тавьж биотехникийн арга хэмжээ авах төсөл арга хэмжээг бүрэн хэрэгжүүлсэн бол бусад 4 төсөл арга хэмжээ одоогийн байдлаар хэрэгжих шатандаа байна.

3.4 Байгаль орчныг хамгаалах сангийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөр нь зорилтот үр дүнд хүрсэн эсэх.

3.4.1 Байгаль орчныг хамгаалах сангийн хөрөнгөөр 2015 онд санхүүжүүлж хэрэгжүүлсэн 58.9 сая төгрөгийн 9 төсөл, арга хэмжээг ондоо багтаан бүрэн хэрэгжүүлж, ашиглалтанд авах комисст хүлээлгэн өгсөн байна. 5 төсөл, арга хэмжээний үр дүнд бий болсон 47.9 сая төгрөгийн хөрөнгийг ашиглагч байгууллагуудын данс, бүртгэлд орлого авч, жилийн эцсийн тайлан тэнцэлд тусгуулсан байна.

2015 онд хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээнийд дүнгээс товч дурьдвал 1.2 сая төгрөгийн хужир давсыг Бугат сумын Хатуугийн уул, Ногооннуур сумын Бахлаг уул, Толбо сумын Борт, Алтай сумын Даваат зэрэг газрын ан амьтадад зориулж цацсан байна. Байгалийн ховор ургамал болох зэрлэг сармисны нөөцийг тогтоох төслөөр 0.7 сая төгрөгөөр 5 дугаар сард Алтай сумын Ёлтын Сар гэр, Бэхт зэрэг нутгаас сармисны үрийг түүж, Ёлтод нутагшуулан тарьсан байна. Суулгацаар ойжуулах төслийн 2.3 сая төгрөгөөр “Орман-ан” ХХКомпани нь Цэнгэл сумын Хара татыр гэдэг газарт 5 га талбайд 1500 ш таримал мод суулгаж 10 дугаар сард комисст хүлээлгэн өгчээ.

Ойн байгалийн сэргээн ургалтанд туслах төсөл буюу 5.9 сая төгрөгийн хөрөнгөөр Баяннуур сумын Батын арал, Харгант арал, Загт, Цэнгэл сумын Аюушийн арал зэрэг газрыг мал амьтнаас хашиж хамгаалах, байгалийн нөхөн ургалтанд туслах ажлыг хийж, Булаг шандны эхийг хамгаалах тохижуулах төслийн 2.8 сая төгрөгөөр Бугат сумын Хатуугийн эх, Улаанхус сумын Хүрэн уулын булаг шандны эхийг хамгаалж, тохижуулжээ.

Аймгийн төвөөс гарах 5 чиглэлийн дагуу байгаль хамгаалах сурталгааны самбар хийж байрлуулах төслийн 9.8 сая төгрөгөөр 5 чиглэлд сурталчилгааны самбар хийж байрлуулж, 16.0 сая төгрөгөөр Хүүхдийн парк болон стадионд 5 ш гүний худгийг гаргаж, ногоон ургамлыг усжуулахад ашиглаж байна.

Ногоон зурвасын дагуу ойн зурвас байгуулах төслийн 3.5 сая төгрөгөөр аймгийн төвд ойрхон Хар толгой гэдэг газарт 3.5 га талбайд 2100 ш таримал мод суулгаж, Толбо сумын чиглэлийн ойжуулалтын талбайг цахилгаанжуулах төслийн 16.3 сая төгрөгөөр цахилгааны дэд станц байгуулж, ашиглалтанд хүлээлгэн өгчээ.

Дээрхи төсөл арга хэмжээнүүдийг гэрээний дүнгээс дутуу санхүүжүүлсэн нь эдийн засгийн чадвхи, орон нутгийн төсвийн хүрэлцээ хангалтгүйгээс төсвийн төлөвлөгөөнд ИТХурлын 2015 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн хуралдааны 53 тогтоолоор тодотгол хийсэнтэй холбоотой байна.

2016 онд сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 5 төсөл арга хэмжээнээс ан амьтанд хужир давс тавих биотехникийн арга хэмжээ авах төсөл арга хэмжээг бүрэн хэрэгжүүлж, 4 төсөл арга хэмжээ хэрэгжих шатандаа явж байна. Тухайлбал: Ургамлын судалгаа явуулах төсөл, арга хэмжээг хэрэгжилтийн явцаас үзэхэд гүйцэтгэгч нь Улаанхус, Сагсай, Цэнгэл, Алтай, Толбо, Дэлүүн сумдаар явж, газар дээр нь судалж, одоогийн байдлаар 159 хуудас бүхий бүтээл турвисан, хэрэгжих шатанд байна. Бусад 3 төсөл, арга хэмжээ аймгийн төвд хэрэгжих шатандаа явж байна.

Зарим төсөл арга хэмжээний хэрэгжилтийн явцыг фото зургаар харуулбал:



2016 оны 2 дугаар сард ан амьтанд хужир давс, өвс тавьж биотехникийн арга хэмжээ авч байгаа байдал



Сангийн хөрөнгөөр 2015 онд хэрэгжсэн сурталчилгааны самбар



Сангийн хөрөнгөөр 2015 онд хэрэгжсэн өндөр хүчдэлийн дэд станц



Сангийн хөрөнгөөр 2015 онд хэрэгжсэн 3.5 га ногоон хэрэм



Сангийн хөрөнгөөр 2015 онд хэрэгжсэн 5 ш гүний худгийн нэг

4. Дотоод хяналтын талаар.

Байгаль орчныг хамгаалах сангийн үйл ажиллагаанд тавих дотоодын хяналтыг зохих түвшинд зохион байгуулжээ.

4.1 Дотоод хяналтын тогтолцооны талаар.

4.1.1 Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 189 дүгээр тогтоолоор батлагдсан “Байгаль орчныг хамгаалах сангийн зохион байгуулалтын тухай журам”-ын 2.1-д “Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 26.3-т заасны дагуу Сангийн хөрөнгийг захиран зарцуулах шийдвэрийг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн гаргана”, 2.2-т “сангийн үйл ажиллагааг зохицуулах, сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулахад хяналт тавих үүргийг 11 хүртэл хүний бүрэлдэхүүнтэй орон тооны бус удирдах зөвлөл хэрэгжүүлнэ” гэж заасан байна.

Харин Байгаль орчныг хамгаалах Засгийн газрын тусгай сангаас 2015, 2016 онд тус аймагт ямар нэгэн хөрөнгө хуваарилагдаж байгаагүй, байгаль хамгаалах санд орон нутгийн төсвөөс хөрөнгө хуваарилж ирсэн тул сангийн хөрөнгийг бүрдүүлэх, сангийн үйл ажиллагааг зохицуулах, зарцуулахад хяналт тавих үйл ажиллагааг аймгийн Засаг дарга, Байгаль орчны газрын дарга хариуцаж ирсэн байна.

4.1.2 Байгаль орчныг хамгаалах сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн төсөл арга хэмжээнүүдийн техникийн нөхцөлийг хангуулах, гүйцэтгэж байгаа ажлын явц, гүйцэтгэлд нь захиалагч болон ашиглагчийн зүгээс хяналт тавих, ажлын бодит гүйцэтгэлийг үнэн зөв тооцох талаар гэрээнд тодорхой тусгажээ. Гэрээгээр хүлээсэн үүргийнхээ хүрээнд гүйцэтгэгчээс гаргасан ажлын гүйцэтгэлийг тухай бүр хянаж баталсаны дагуу санхүүжилтийг олгож ирсэн байна.

4.1.3 Ажлын гэрээнд захиалагч болон ашиглагч байгууллагууд гэрээ хийж байгаа ба ашиглалтанд хүлээж авах комиссын бүрэлдэхүүнд ашиглагч байгууллагын төлөөлөл буюу мэргэжилтэн зайлшгүй орж актад гарын үсэг зурж байгаа нь ашиглагч байгууллага төсөл, арга хэмжээний ажлын явц, үр дүнд хяналт тавих эрхээр хангагдаж, тухайн ажлын гүйцэтгэлд байнгын хяналт тавьж ирсэн байна.

Ингэснээр тус сангийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа аливаа төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд тавигдах дотоодын хяналтын тогтолцоо үндсэндээ бүрдсэн байна.

4.2. Сангийн үйл ажиллагаанд хийгдэж байгаа дотоод хяналт шалгалтын талаар.

4.2.Байгаль орчныг хамгаалах сангийн хөрөнгөөр 2015, 2016 онд хэрэгжсэн төсөл, арга хэмжээний үйл ажиллагаа, хэрэгжилтийн байдалд Байгаль орчны газрын мэргэжилтнүүдийн зүгээс 26 удаа хяналт шалгалт явуулж дүгнэлт гаргаж, зөвлөмж өгч хяналт, шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлуудыг хугацаанд нь засаж залруулах, арилгуулах талаар тодорхой арга хэмжээ авч, биелэлтийг бүрэн хангуулсан байна.

4.3 Шилэн дансны тухай хуульд заасны дагуу мэдээллийг ил тод нээлттэйгээр олон нийтэд мэдээлж байгаа талаар.

Шилэн дансны тухай хуулийн зарим заалтуудыг хангалтгүй хэрэгжүүлсэн байна.

3.2.1 Байгаль орчны газрын Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг Аудитын газраас 2015 оны 10,11 дүгээр сард шалгахад шилэн дансны нэгдсэн мэдээллийн санд байгаль хамгаалах сангийн талаарх мэдээллийг огт байршуулаагүй байсан.

Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд Байгаль хамгаалах сангийн хөрөнгийн талаарх мэдээллийг хугацаанд нь байршуулаагүй нягтлан бодогчид 2015 онд 12 дугаар сард сахилгын шийтгэл ногдуулж, цалинг 1 сарын хугацаанд 15 хувиар хасаж ажлын хариуцлага тооцсон байна.

Харин 2016 онд сангийн хөрөнгөөр хэрэгжсэн 5 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаа буюу гэрээний талаарх мэдээллийг шилэн дансны нэгдсэн мэдээллийн санд бүрэн байршуулжээ.

Аудит хийх явцад байгууллагад шилэн дансны мэдээллийн самбар байгаа эсэх, мэдээллийг хэрхэн байршуулж байгаа байдлыг газар дээр нь шалгаж үзэхэд мэдээллийн самбарыг заасан стандартаар нь хийж, ил харагдахаар газарт байрлуулсан байна.

Нийцлийн аудитын үр дүнгээр ямар нэгэн зөрчил, дутагдал илрээгүй ба холбогдох байгууллага, албан тушаалтнуудад 2 заалт бүхий зөвлөмжийг өгсөн болно.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын үр дүнд үндэслэн дараах дүгнэлтүүдийг хийж байна.

1.Байгаль хамгаалах сангийн үйл ажиллагааны талаар.

1. Байгаль хамгаалах тухай хууль, эрх зүйн актуудыг мөрдөж ажилласан байна.
2. Байгаль хамгаалах сангийн эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс бүрдүүлж 2015-2016 онд 111.1 сая төгрөгийг хөрөнгийг төвлөрүүлсэн байна.
3. Байгаль орчныг хамгаалах сангийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулж, худалдан авах ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулжээ.
4. 2015, 2016 онд энэхүү сангийн хөрөнгөөр хэрэгжсэн төсөл арга хэмжээнүүд нь хуулиар тодорхойлсон зорилго, зорилттой нийцэж байгаа боловч байгалийн эрсдэлтэй унаган төрх байдлыг хамгаалах, бохирдлыг багасгах, эн тэргүүнд шаардлагатай төсөл, арга хэмжээг зөв сонгон авч сангийн хөрөнгийг түүнд чиглүүлэн хэрэгжүүлж чадаагүй байна.
5. Байгаль орчныг хамгаалах сангийн үйл ажиллагаанд дотоодын хяналтыг зохих түвшинд зохион байгуулсан байна.

ЗӨВЛӨМЖ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын үр дүнд үндэслэн дараах зөвлөмжүүдийг өгч байна. Үүнд:

I.Аймгийн Засаг дарга А.Гылымхан танаа:

1. Байгаль хамгаалах сангийн хөрөнгийг байгалийн унаган төрх байдалд сэргөөр нөлөөлж буй эрсдэлээс хамгаалах, бохирдлыг багасгахад нөхөн сэргээх чиглэлд эн тэргүүнд төсөл, арга хэмжээг чиглүүлэхээр төлөвлөж, зарцуулах.

II.Байгаль орчны газрын дарга Ш.Марат-д:

2. Байгаль орчныг хамгаалах сангийн хөрөнгөөр 2016 онд хэрэгжих шатандаа байгаа төсөл, арга хэмжээнүүдийг гэрээний хугацаанд бүрэн хэрэгжүүлэх арга хэмжээ авах.

Холбогдох байгууллагын санал

(.....Байгууллагын нэрийг оруулах.....) ирүүлсэн санал:

БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН
БАЙГАЛЬ ОРЧИН,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР
83126 Баян-Өлгий аймags, Өлгий сум,
Утас/Факс: (976) 7042 2667

8016-09-26 № 142

танил _____-ны № _____-т

АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Үндэсний Аудитын газраас 2016 онд Монгол Улсын
Ерөнхий аудиторт нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил
үйлчилгээний төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу тус аймгийн
Байгаль орчныг хамгаалах санд хийгдсэн аудит нь
холбогдох хууль, журам, эрх бүхий хүрээнд үнэн зөв
хийгдсэн болно.

ДАРГА Ш.МАРАТ

8316120610 9006974

ТАЙЛАНГ ХЯНАЖ БАТАЛГААЖУУЛСАН:

АЙМГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Х.БЕКЕН

ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР Х.ЖЕНИСБЕК

ТАЙЛАНГ БЭЛТГЭСЭН:

АХЛАХ ШИНЖЭЭЧ
ШИНЖЭЭЧ С.САЛТАНАТ
Х.ЕРКЕБУЛАН